

ТӨРИЙН УДИРДЛАГА БА УЛС ТӨРИЙН НӨЛӨӨЛӨЛ

Ю.Атар

Доктор (Sc.D), дэд профессор
(МУБИС-ийн Улс төр судлал, социологийн тэнхмийн эрхлэгч)

Хураангуй

Сүүлийн үед төрийн удирдлагын өнөөгийн тогтолцоонд оршиж буй сул тал, бэрхшээлтэй асуудлыг улам бүр ойлгож мэдэрч эхэлсэн бөгөөд улмаар ил тод байдал, эргэж тайлагнах тогтолцоог нэвтрүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага хурцаар тавигдах боллоо.

Төрийн удирдлага, түүний үр нөлөө, боловсон хүчний бодлого, удирдлагын арга барил, нам, төрийн болон нам хоорондын харилцаа зохист хэлбэрт орж чадахгүй байна. Ялангуяа парламентаас гүйцэтгэх эрх мэдэлд, иргэний нийгмээс засаг төрд тавих хяналтын тогтолцоо байхгүйгээс шалтгаалж хатуу төвлөсөн удирдлагад шилжих хандлага нүүрлэж байна. Үүнээс улбаалан төрийн үйл хэрэгт оролцох, эрх баригчдад нөлөө үзүүлэх, хяналт тавих зэрэг эрхээ хэрэгжүүлэх боломж иргэдийн өөрсдийн нийгэмшилт болон төрийн идэвхгүй байр сууринаас хамаарч төлөвшлөө олохгүй байсаар байна.

Захиргаа нь засаглалд захирагдах зарчим

Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа өөрийн гэсэн орчинд явагддаг. Энэхүү орчинтойгоо хэрхэн харьцах асуудал судалгаанд эртнээс анзаарагдаж ирсэн бөгөөд орчинтой харьцах харьцаа нь юуны түрүүнд улс төртэй холбогдож гарч ирдэг. Иймд төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд улс төрийн нөлөөлөл ямар байх вэ? нөлөөлөл нь хаагуур дуусдаг вэ? зэрэг асуудал зөвхөн онолын төдийгүй практик ач холбогдолтой байна.

Францын судлаач Анри Шардоны тэмдэглэснээр «Захиргаа нь улс төрийн засаглалд захирагдсан байх ёстой». Энэ утгаараа захиргааны байгууллага нь гүйцэтгэх засаглалынхаа мөн чанарт тулгуурлаж явагдах нь зүй ёсны хэрэг билээ. Захиргааны байгууллага нь засаглалдаа захирагдахгүй бол нийгэм анархи байдалд орох, нийгэмд захиргааны дарангуйлал тогтож, улс төрийн засаглал ямар ч эрх мэдэлгүй хоцрох, чухал шийдвэр улс төрийн засаглалын зүгээс бус гүйцэтгэх засаглалаас гарах зэрэг олон сөрөг хүчин зүйл гарч ирдэг байна.

Улс төрийн засаглал захиргааны байгууллагын үйл ажиллагаатай шууд холбоотой боловч түүнтэй хутгалддаггүй. Улс төрийн засаглал нь санаачлах, удирдан чиглүүлэх, үнэлж дүгнэх, зөвлөх, уриалан дуудах чиг үүргүүдийг хэрэгжүүлж байдаг. Нөгөө талаар улс төр ба захиргааны харилцааны асуудал зөрчилтэй мэт санагдаж магадгүй.

Засгийн газар өөрт нь хамаарах асуудлын хүрээнд улс төрийн талаар хэнээс ч хараат бус байх нь чухлаар тавигддаг. Учир нь:

1. Засгийн газраас нийгмийн амьдралын олон асуудлыг хөндсөн шийдвэр гаргах үйл явц парламентынхаас илүү түргэн байдаг.
2. Засгийн газар бодлогоо хэрэгжүүлдэг учраас нийгмийн бүхий л давхаргын эрх ашгийг мэдэрч, түүнд зохицох арга хэмжээ авдаг байна.

Парламентат ёс хөгжсөнөөр ямар ч тохиолдолд улс төрийн засаглалын үйлдлийн хариуцлагыг засгийн газар хүлээх болсон. Захиргааны байгууллага асуудлыг гүнзгийрүүлэн судалж, улс төрийн шийдвэр гаргах хэрэгтэй болдог төдийгүй засгийн газар өөрийн үйл ажиллагааны доголдлыг хянадаг чадвартай байх ёстой билээ¹. Захиргааны байгууллагын хийж байгаа ажил ямагт улсын шинж

чанарыг агуулдаг. Энэ утгаараа засгийн газрын хариуцлага нь эрх мэдлийг зааглах явдлын шууд үргэлжлэл болдог төдийгүй захиргааны байгууллага ямар ч нөхцөлд улс төрийн амьдралын орчинд оршин тогтнодог жамтай юм.

Төвийг сахих зарчим

Төр бүрэн хүчин чадлаараа ажиллахын тулд улс төрийн шийдвэр гаргах үйл явцад шууд оролцдоггүй ч тэдгээрийг гардан ажил хэрэг болгодог ажилтан албан хаагчидтай байдаг журамтай. Энэ нь их эрх мэдэлтэй, албан ёсны хяналт, шалгалт харьцангуй цөөнтэй, чадварлаг ажилтны удирдсан байгууллага зайлшгүй үр дүнд хүрдгийн илэрхийлэл² мөн.

Судлаач М.Вебер төрийн захиргааны албан хаагч хүн улс төрөөр оролдох ёсгүй бөгөөд төвийг сахих зарчмыг баримталж өөрийн удирдан захирах үүргийг л гүйцэтгэх учиртай гэж тэмдэглэж байсан бол Америкийн судлаач В.Вильсон «Удирдлагын тухай сургаал» бүтээлдээ: «Албан хаагч хариуцлагаа ухамсарлах тусам зоригтой, юманд бодитой хандаж нэр хүндээ өндөрт өргөж явахыг боддог» гэж тэмдэглэсэн байдаг нь тохиолдлын зүйл биш болов уу.

Төрийн албан хаагчид ард иргэдийн амьдралд нөлөөлдгийн хувьд иргэд олон нийтийн итгэлийг хүлээж байдгийнхаа хувьд өөрсдийн үйл ажиллагааныхаа төлөө үндэсний хууль тогтоомж, ард иргэдийн өмнө хариуцлага хүлээх учиртай билээ.

Харамсалтай нь өнөөдөр монголд улс төрийн албан тушаалтан болон төрийн албан хаагчдыг халж сольсны улмаас төрийн захиргааны байгууллагууд байнгын хөдөлгөөнд оршиж байна. Энэ нь төрийн албан хаагчдын залгамж чанар алдагдаж, хариуцлагагүй ажилласан тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжгүй болгож, улмаар төрийн үйл ажиллагааны үр нөлөөг бууруулаад зогсохгүй, ардчилалд итгэх монголчуудын итгэл, сэтгэлийг мохоох аюултай байна³.

Төрийн боловсон хүчний бодлого алдагдаж, түүнд шударгаар өрсөлдөн ажиллах боломж хумигдлаа. Мэргэшсэн алба намчирхалд автаж, улс төрийн нам, тэдгээрийн удирдагчдад хахууль, хандив өгөх нь төрийн албанд орох үндсэн нөхцөл, болзол болсон учраас төрийн мэргэжлийн алба, албан тушаалтнууд хэт улс төржиж байна. Төрийн албан хаагчийг намд элсэхийг шаардах явдал нь зөвхөн сонгуульд ялахын тулд олон дэмжигчтэй байх нь чухал болж иржээ.

Манай нам, төр, төрийн албан тушаал өөрөө арилжааны үндсэн хэрэгсэл болон хувирав. Энэ нь нийгмийг бүх талаар доройтуулан тамирдуулж байна. Өөрөөр хэлбэл энэ байдлаас улбаатай авилгал нь төрийн янз бүрийн албан тушаалуудыг хамарсан томоохон сүлжээ болтлоо хөгжжээ. Аливаа асуудлыг албан ёсны институт биш, явцуу бүлгийн хүрээнд хуйвалдаанаар шийдвэрлэх нь түгээмэл болов.

Энэ бүх гацаанаас гаръя гэвэл Үндсэн хууль, төрийн албаны тухай хуулиар намын харъяалалаар ялгаварлахыг хориглосон заалтыг хэрэгжүүлэх механизмыг хатуу тогтоох нь монголын төрийн тогтвортой байдлыг хангах нэг нөхцөл хэмээн үзнэ. Нөгөөтэйгүүр мэргэшсэн боловсон хүчний чадамж улс төрийн нөлөөллөөс хамааран бүрэн илэрч чадахгүй байгааг үүнтэй шууд холбож үзэхээс өөр аргагүй байна.

Олон түмний зүгээс ихээхэн шүүмжлэлтэй хандаж байгаа асуудлуудын нэг нь төрийн боловсон хүчнийг шилж сонгох асуудал юм. Энэ удаа ч төрийн албаны боловсон хүчнийг шилж сонгохдоо намын шалгуураар сонголт хийснийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Үүнд улс төрийн өндөр албан тушаал хамаарахгүй.

Төрийн жинхэнэ албанд мэдлэг чадвартай, тухайн албан тушаалын шаардлагыг хангасан, тухайн байгууллагын зорилго зорилтыг хэрэгжүүлж чадах мэргэшсэн хүмүүсийг шилж сонгон авч ажиллуулах нь шинэчлэлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэх үндэс сурвалж болно.

Төр ба нам

Өнөөдөр Монголын нийгмийн бодит амьдрал нь захиргааг улс төржүүлэх, удирдлагын аппаратыг өөртөө захируулах, түүний ажилтнууд улс төрийн хувьд эрх баригч хүчинд үнэнч байхтай холбоотой гарч буй асуудлуудад дуугүй өнгөрөх боломжгүй юм. Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх явцад олон сая саяар нь үрж зарцуулсан хөрөнгө мөнгө, албан татварын хүнд дарамт гээд олон нийтийн дургүйцлийг хүргэх зүйл нь их гарах боллоо. Буруу бодлого баримталсан нөхцөлд түүний үр дагавар ихээхэн хор уршигтай байдаг.

Монголд ардчилсан төр төлөвших үйл явц улс төрийн намуудын төлөвшилтэй шууд уялдаатай явах ёстой. Намуудын төлөвлөөс парламентат ёсны хөгжил, төрийн тогтвортой байдал олон талаар шалтгаална. Гэтэл улс төрийн намууд парламентын нам болон бүрэн төлөвшихийн оронд УИХ-ын гишүүнд нэрээ дэвшүүлэх, албан тушаалд томилогдохоор асуудлыг хязгаарлах, улс төрийн бизнесийн бүлэглэлд ордог, ашиг сонирхолд хөтлөгдөх явдал нийтлэг байна. Нам бүр нийгмийн тодорхой хэсгийн улс төрийн ашиг сонирхлыг илэрхийлэх зарчмаас ухарч, хэсэг хүний албан тушаалын төлөөх шударга бус өрсөлдөөн, хуурамч эвлэрэл, хуйвалдаан болоход хүргэж байна.

Өнөөдөр улс төрд мөнгө асар их үүрэгтэй бөгөөд ардчиллын бүх түвшний байгууллагын үйл ажиллагааг гажуудуулж байна. Өөрөөр хэлбэл мөнгө улс төрд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд энэ нь тэгш бус эдийн засгийн эрх мэдлийг улс төрийн давуу тал болгон хувиргаж байна. Энэ нь эрх баригчид төр, улс төрийн намуудын зүгээс иргэдийн санаа бодолд явцуу зорилгоор нөлөө үзүүлэх, манипуляцид автуулах хөрс болсоор байгаа⁴ билээ.

Парламентын гишүүд дотроос томилогдсон засгийн газрын үйл ажиллагаанд парламентын зүгээс хатуу хяналт тавих бололцоо бараг үгүй. Тэр тусмаа ерөнхий сайд нь намын дарга, парламентын гишүүн, сайдууд нь намын удирдлага, нэр нөлөө бүхий хүмүүс байвал, ямар нэгэн хяналтын тухай ярих боломж байхгүй. Ийм байдал нь хууль тогтоох ба гүйцэтгэх засаглал хоёулаа улс төрийн нэгэн явцуу бүлэглэлийн эрхшээлд орж, тэрхүү бүлэглэл дураар авирлах нөхцлийг бүрдүүлж байна гэсэн үг юм.

УИХ, Засгийн газрын бүрэлдэхүүнийг хольж хутгасан нь парламентаас засгийн газраа хянах механизмыг сулруулж байна. Олонх болсон улс төрийн хүчин өөрсдөөсөө бүрдүүлсэн засгийн газраа ямар ч аргаар хамаагүй зөвхөн дэмжихэд парламентыг чиглүүлж, Засгийн газрыг хянах бүрэн эрхийг нь явцууруулах хандлага ажиглагдах болсон. Улмаар түүний даалгавар гүйцэтгэх хүрээг явцууруулснаар намаар төрийг орлуулах хандлага бий болгож байна.

Ардчилсан нийгэмд төр нь иргэддээ үйлчлэх гол үүрэгтэй. Энэ үйлчилгээ нь ил тод шаардлагад нийцэхгүй байх нь авилгал дэлгэрэх гол нөхцөл болдог байна.

Төр засаг нь сул, чадваргүй эсвэл бүр огт байдаггүй хөгжиж буй орнууд олон олон ноцтой хүндрэл бэрхшээлийн уг сурвалж болж байна. Төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүмүүс ажил үүргээ дан ганц өөрийн эрхээр гүйцэтгэдэг гэвэл эндүүрэл болно. Эрх ашгийг бүлгүүдийн төлөөлж байгаа хүмүүс тэдний үйл ажиллагаанд байнга нөлөөлөхийг оролдож, байгууллагуудын бодлого, шийдвэрт өөрийн бүлгийн эрх ашгийг түлхүү тусгахыг оролддог. Удирдлагын дээд түвшинд албан тушаалаа ашиглан хуурч мэхлэх, хувийн эрх ашгийг эрхэмлэн төр засгийн эрх ашигт хохирол учруулахад намын харъяаллаар албан тушаалд томилдог явдал нөлөөлж байна. Үүнээс улбаалан монголын нийгэм намуудаараа хуваагдмал байдалд орлоо.

Намын харъяаллаар албан тушаалд томилдог системээс үүдэн ихээхэн газар авсан коррупци төрийн албан шинэчлэлд саад учруулж байна. Хэн нэгэн захирагдагч

буюу төрийн албан хаагч өөрийн хувийн сонирхлыг эздийнхээ ашиг сонирхлоос дээгүүр тавихаар улс төрийн авлига үүсдэг явдал өнөөдөр нэгэнт газар авчээ. Хээл хахууль, эрх мэдлээ урвуулан ашиглах, гэмт хэрэгтнүүдийн айлган сүрдүүлэлт энэ бүгдээс болж ардчиллын хариуцлага суларч байна. Улс төрийн сонгуулиар төрийн удирдлаганд гарсан зарим хүчин төрийн албаны мэргэшсэн албан хаагчийн багийг удирдлага солигдсон нэрээр өөрийн хүнээ дэвшүүлснээр тогтолцооны гажуудал давтагдаж нийгэмд сөрөг нөлөөг үзүүлж байна.

Улс төрийн аль ч нам гишүүд дэмжигчид, олон түмнээсээ тасарсан явцуу хэсэг болон хувирах хандлага ажиглагдаж, олон түмний санаа бодолд итгэл даахгүй хандлага давамгайлах боллоо. Сонгогчид сонгох эрхээ хэрэгжүүлэхэд эрх зүйн болон зохион байгуулалт, ажил хэргийн тодорхой бэрхшээл гарсаар байна. Засаг захиргааны нэгжид хийгддэг бүртгэл, сонгуулийн үеийн шилжилт хөдөлгөөний зохицуулалтыг хариуцсан төрийн байгууллагуудын замбараагүй байдал улс төрийн зүгээс сонгуулийн дүнг будилаантуулах таатай нөхцлийг бүрдүүлж байна.

УИХ, ИТХ нь бүрэн эрхийн хэрэгжилтийнхээ хугацаанд иргэдийн санаа бодлыг гаргах шийдвэрийн өмнө хэрхэн сонсож, харьцуулж, судлан тусгаж байх талаар нэгдсэн баримтлал, зайлшгүй дагаж мөрдөх тодорхой хууль, тогтоомж байхгүй байна. Төлөөлөгчдийн байгууллагыг ард түмэн хянах бололцоо бага, тэдгээрийн шийдвэр гаргах үйл явц олон түмний өмнө нээлттэй, ил тод явагддаггүй учраас эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа иргэдийн ардчилсан үнэлэмж, итгэлийн төлөвшид таатай орчин, нөхцлийг хангахгүй байна.

Төр бизнесийн холбоо

Бизнес эрхлэгч бүр төр, засгийн албан тушаалд тэр бүр амжилт олж чаддаггүй. Пүүс компанидаа ажиллаж ирсэн арга барилаар хандаж тушаал, заавар өгч чаддаг боловч, харин шийдвэрээ олон түмэнд тайлбарлан таниулах, тэвчээр дутмаг учраас эсэргүүцэл бэрхшээлтэй тулгарч байна.

Улс төрийн намуудын удирдлага улс төрийн намаасаа үл хамааран эдийн засгийн ашиг сонирхлоороо далдуур нэгдэх болсноор улс төрийн намуудын учир утга алдагдахад хүрч байна.

Эрх баригчдын зүгээс нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг олж харах, улмаар үр өгөөжтэй асуудлыг шийдвэрлэх чадамжийг дээшлүүлэх явдал чухал юм. Түүнчлэн захиргааны ажилтнууд бодлого боловсруулахад ихээхэн үүрэгтэй оролцоод зогсохгүй нарийн ээдрээтэй олон асуудалд хариу өгөх хэрэгтэй байна. Төр, засгийн албанд эрх ашгийн зөрчлөөс зайлсхийх хүчин төгөлдөр хуулийн заалт, захирамжуудыг ягштал биелүүлэх шаардлага гарч ирж байна.

2000 оны долдугаар сарын 15-наас дагаж мөрдөж буй нэмэлт өөрчлөлтүүдийн нэлээд нь манай үндсэн хуулийн ардчиллын механизмыг эвдэхэд хүргэжээ. Тухайлбал эрх мэдлийн хуваарилалтын онолын үүднээс хандвал Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн байж болох энэ хувилбарыг нь засгийн эрх мэдлийн хуваарилалтын үндсэн зарчимтай харшилж, ялангуяа Монгол шиг цөөн тооны хүнтэй парламентад тохиромж муутай гэж үзэх үндэстэй. Энэ нь хэрэг дээрээ засгийн газарт УИХ хяналт тавих оролцоог багасгаж, зарим нөхцөлд үгүй болгож буй хэрэг юм. Үүнээс улбаалан Парламент Засгийн газар хоорондын тэнцвэрт байдал алдагдаж, гүйцэтгэх засаглал давамгайлах байр суурьтай болж байна.

Сонгуульд ялсан намын лидерүүд Засгийн газрыг бүрдүүлж парламент дахь гишүүддээ нөлөө үзүүлж байгаа учраас засгийн газраас оруулсан хуулийн төсөл, бусад баримт бичиг парламентаар төвөггүй батлагдах боломжтой юм. УИХ-ын гишүүд гүйцэтгэх байгууллагыг орлон төсвийн хөрөнгө гардан зарцуулдаг гажуудал нэмэгдсээр, бүр хуульчлагдаад байна.

Захиргааны удирдлага плюралист бүтэцтэй байгаа нөхцөлд гарч болох сөрөг үр дагавар гэвэл хамгийн хүчтэй, эрх ашгаа бататгаж чадсан бүлгийнхэн бодлого боловсруулахад давамгайлах хандлагатай байна. Засгийн газар хүмүүсийг хооронд нь холбож байдаг хэлхээ холбоогоо тасалж, эрх мэдэл, нөөц баялгийг гартаа төвлөрүүлэх, бидний цаг, мөнгө, нигүүлсэнгүй сэтгэлийг өөртөө ашиглахыг илүүд үзэх боллоо. Өөрөөр хэлбэл хөрөнгө мөнгөөр улс төрд орж ирэх хандлага, арга саам эрээ цээргүй байдал үргэжлэх болов.

Засгийн газар хуулийн биелэлтийг хариуцан иргэдтэй нягт холбоотой байж гаргаж буй шийдвэр, хийх ажлынхаа талаар үндэслэгээ, нотолгоогоо иргэддээ танилцуулан дэмжлэг авахын оронд санхүү эдийн засгийн тусламж үзүүлж буй олон улсын байгууллагад илүү ханддаг, амыг нь хардаг хөгжиж буй улсуудын нийтлэг дүр төрх зонхилж байна.

Иймд улс төрийн цэвэр өрсөлдөөний зарчмыг нэвтрүүлж, улс төрийн хүрээ эдийн засгаас салгах механизмыг бүрдүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Төрийн хяналт

Төрийн захиргааны үйл ажиллагааг зохих ёсоор зохион байгуулахад улс төрийн удирдагчдын шийдвэрийг нягт нямбай, үнэн шударга хэрэгжүүлэх, нөхцөл байдлын онцлогоос хамааран уян хатан хандах, ажлаа мэдэж мэргэжлийн талаас бие дааж ажиллах, мөн бага зардлаар үр ашигтай ажиллах явдал чухлаар тавигдаж байна. Тухайлбал, төрийн байгууллага ба түүний хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, гүйцэтгэх удирдлагын нэгж, хяналтын тогтолцоонд анализ хийх, төрийн ажилтны улс төрийн хувьд төвийг сахисан байх арга замыг тодорхойлох, намын харъяаллаар албан тушаалд томилдог, албан тушаалд байлгах, огцруулахыг улс төрийн учир шалтгаанаар шийдвэрлэж буй үр дагаварыг тодорхойлох, захиргаа нөлөө бүхий бүлгүүдийн дэмжлэгийг авахын тулд тэдний бодлого боловсруулах, улс төрийн шийдвэр гаргах үйл явцад албан бусаар оролцуулах боломжийг судлах, төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулж буй одоогийн журмыг шинэчлэн сайжруулах арга замыг илэрхийлэх, иргэдтэй яаж харьцаж байгаа, тэр хэмжээгээр тухайн засаглалыг жирийн хүмүүс юу гэж хүлээн авч байгаад анализ хийх явдал зэргийг онолын болон практик түвшинд судлан шинжлэх шаардлага нэгэнт бий болжээ. Захиргааны байгууллагуудад шинэчлэл хийх явдал нь захиргааны байгууллагыг илүү ил тод, хариуцлагатай, үр нөлөөтэй мэдрэмжтэй болгох хойшлуулалгүй зорилт мөн билээ.

Төрийн зүгээс үзүүлэх хууль зүйн мэдээллийн үйлчилгээ сул, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын ажлын цар хүрээ хязгаарлагдмал, сонирхолын бүлгүүд хийгээд иргэдийн зүгээс гаргаж буй идэвхи санаачлага муу байна.

Төр, захиргааны албан тушаалтны үйл ажиллагаанд тавих иргэний нийгэм, иргэдийн хяналт муу, гар харсан хуучин сэтгэлгээ давамгайлж, засаг төр нь иргэддээ үйлчлэх ёстой юм шүү гэдэг сэтгэлгээ хөгжихгүй, харин аврал эрж, гар харах, авилгал хүнд суртал газар авч байна.

Албан тушаалтнуудыг хянах тогтолцоо сул, түүнийг хэрэгжүүлэх Төрийн албаны зөвлөл эрх баригчдаас хараат, бие даасан статус нь бүрхэг, бүхэлдээ хариуцлага тооцох механизм эрх зүйн хувьд сул байна. Нөгөө талаар парламент дахь цөөнхийн эрх хязгаарлагдмал, олонхид тавих хяналт сул хэвээр байна. Үүний улмаас УИХ-аас Засгийн газрыг хянаж чадахгүйд хүрч, зөвшлийн үйл явцыг хуулиас дээгүүр тавих болов

Өнөөдөр омбудсмений албыг жинхэнэ утгаар нь ажиллуулах шаардлага байна. Омбудсмен нь төрийн алба болон төрийн албан хаагчдад хяналт тавьдаг байгууллага юм. Мөн төрийн байгууллага албан тушаалтнаас болж эрх нь

зөрчигдсэн гэсэн ард иргэдийн гаргасан санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч нягтлан шинжлээд, засаж залруулах алхам хийдэг.

Төрийн байгууллага, албан тушаалтнууд зөвхөн иргэдийнхээ өмнө үүрэг хүлээж, хариуцан тайлагнахын гол ач холбогдол нь үүгээр тодорхойлогдоно. Улс төрийн намууд нийтийн эрх, ашиг сонирхлын төлөө хувийн эрхээ сайн дураар хязгаарлахыг ухамсарлан гишүүдээ нэр дэвшүүлж, төрийн албан тушаалд ёс журмын дагуу өрсөлдүүлэх цаг нь болжээ.

Төрийн байгууллага, албан тушаалтан иргэд, сонгогчдын болон дээд шатны байгууллагын өмнө ажлаа хариуцан тайлагнахын зэрэгцээ өөр хоорондоо хяналт тавьж, тайлагнаж, хариуцлага хүлээдэг байх нь ардчилсан ёсны үндсэн зарчмын нэг мөн билээ.

Дүгнэлт

Захиргааны хариуцлагыг дээшлүүлэх нэг чухал арга бол төрийн захиргааны удирдлага олон нийттэй ойр холбоотой, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөнгөн шуурхай ажиллах явдал юм. Ингэж ажиллаж чадах байгууллага бол омбудсмений алба яахын аргагүй мөн юм.

Дэлхийн улс орнуудад үйл ажиллагаа явуулж буй омбудсмений алба нь жил ирэх тусам олон улс оронд шинээр байгуулагдан ажиллах болсон. Тэр дундаа ардчилал хөгжсөн улс орнуудад төрийн удирдлагын нэг хэсэг болох төрийн алба болон албан хаагчдын үйл ажиллагааг хянах, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой иргэдийн гаргасан гомдол, санал, өргөдөл зэргийг хүлээн авч шийдвэрлэдэг байгууллага, хамт олонд онцгой анхаарах, чухалчлан үзэж, аливаа асуудлыг шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахад ихээхэн анхаардаг байна.

Орлогын ялгаатай байдал, амжиргааны түвшний зөрөө, ахуй, амьдралын орчны ялгаа, төрийн үйлчилгээний хүнд суртал, үл тоомсорлох хайнга байдал зэрэг төрийн зүгээс бүрдүүлбэл зохих оролцооны суурь нөхцөл хангалтгүйгээс иргэн бүрийн оролцооны тэгш боломж хязгаарлагдмал байна. Ажилгүйдэл, ядуурал иргэдийн оролцоонд саад учруулдаг эдийн засгийн бусад бэрхшээлийг багасгах нь чухлаар тавигдаж байна.

Өнөөдөр хариуцлагатай засаг төр хэрэгтэй байна. Энэ нь явцуу бүлгийн дур зоргийн үйл ажиллагааг хязгаарлан, төрийн үйл ажиллагааны ил тод байдал, улс төрчдийн хариуцлагын тодорхой шалгуурыг бий болгох гол хүчин зүйл болно.

Төрийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүний эрх, ард иргэдийнхээ ашиг сонирхолд тууштай үйлчлэхэд чиглэгдэх ёстой болов уу. Нөгөө талаас төрийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа олон түмэнд ил тод, хууль ёсны байж, иргэдийн зүгээс тэдгээр байгууллагад итгэх итгэл, өгөх үнэлгээ дээшилнэ.

Ном зүй

¹ Майкл Жонстон. Сайн засаглал: хуулийг дээдлэх ёс, ил тод байдал ба хариуцлагын тогтолцоо. АШСТО-ын олон улсын 5 дугаар бага хурал. Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл. УБ., 2003, 9 дэх тал.

² Францис Фукуяама. Төрийг бэхжүүлэх нь: Хорин нэгдүгээр зууны засаглал ба дэлхийн дэг журам. УБ., 2005, 91 дэх тал.

³ Монголын хүний хөгжлийн илтгэл. 2000. Монгол улсын Засгийн газар, НҮБХХ, 2000, 17 дахь тал.

⁴ Transparency international. Corruption index. www.transparency.org

⁵ Freedom House Survey. Nations in Transition. Reports, Mongolia, www.freedomhouse.org